

2026 оны 06 дугаар сарын 11-ний өдөр

**УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 10 дахь хэсэгт иргэн эвлэлдэн нэгдэх эрхтэй болохыг, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийг тус тус хуульчилсан. Түүнчлэн Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт ардчилал, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдлыг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болгон тунхагласан байдаг.

Улс төрийн нам нь ардчилсан тогтолцооны үндсэн институтийн нэг бөгөөд иргэдийн улс төрийн оролцоог хангах, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх, төрийн эрх мэдлийг ардчилсан аргаар хэрэгжүүлэх үндсэн нөхцөлийг бүрдүүлдэг. Иймд улс төрийн намын үйл ажиллагаа тасралтгүй, дотоод ардчилалтай, санхүүгийн хувьд ил тод, бодит нөхцөл байдалд нийцсэн эрх зүйн зохицуулалттай байх шаардлагатай.

2023 онд шинэчлэн найруулсан Улс төрийн намын тухай хууль нь улс төрийн санхүүжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилготой боловч хэрэгжилтийн явцад тодорхой хүндрэл, эрх зүйн зохицуулалтын хийдэл үүсээд байна. Үүнд:

- намын санхүүгийн үйл ажиллагааг улсын хэмжээнд нэг дансны тогтолцоогоор хэрэгжүүлэх зохицуулалт нь орон нутгийн намын байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны бие даасан байдал, хэвийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж байгаа;
- намын төлөөллийн төв байгууллага болон хяналтын байгууллагын бүрэлдэхүүнд ямар нэгэн өөрчлөлт оруулах тохиолдол бүрд Намын Их хурлыг тухай бүр зарлан хуралдуулах шаардлага үүсэж байгаа;
- намд өгөх хандивын дээд хэмжээ нь эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, инфляцын түвшин болон сонгуулийн үйл ажиллагааны бодит зардлын хэрэгцээтэй нийцэхгүй байгаа;
- хуулийн этгээдийн бие даасан байдлыг хязгаарлаж, зарим салбарт ялгавартай хандаж, Үндсэн хуулийн эрх тэгш байдлын зарчим алдагдах нөхцөл үүсгэж байгаа зэрэг болно.

Иймд Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, улс төрийн намын үйл ажиллагааны бодит хэрэгцээ, Үндсэн хуулийн суурь зарчим, ардчилсан засаглалын шаардлагад нийцүүлэн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хэрэгжилтийн явцад үүссэн хүндрэл, хийдлийг арилгах шаардлага бий болсон болно.

Хоёр.Хуулийн төслийн зорилго

Хуулийн төслийн зорилго нь улс төрийн намын дотоод зохион байгуулалт, санхүүжилтийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, улс төрийн намын хэвийн, тасралтгүй, ил тод үйл ажиллагааг хангахын зэрэгцээ иргэн, хуулийн этгээдийн улс төрийн оролцооны эрхийг Үндсэн хуульд нийцүүлэн тэнцвэртэйгээр хангахад оршино.

Гурав.Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь дараах үндсэн харилцааг зохицуулна:

3.1.Намын орон нутгийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны бие даасан байдлыг хангах

Аймаг, нийслэл, дүүргийн намын байгууллагад тус бүр нэг банкны данс эзэмших эрх олгож, өдөр тутмын үйл ажиллагааг төвлөрсөн бус, шуурхай байдлаар хэрэгжүүлэх эрх зүйн боломжийг бүрдүүлнэ. Энэхүү зохицуулалтын үр дүнд орон нутгийн намын байгууллагын үйл ажиллагааны бие даасан байдал хангагдаж, төв байгууллагын ачаалал буурахын зэрэгцээ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрөө удирдах зарчимтай нийцэх нөхцөл бүрдэнэ. Мөн санхүүгийн ил тод байдал, хариуцлагыг хадгалан үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх ач холбогдолтой.

3.2. Намын шийдвэр гаргах үйл ажиллагааны шуурхай байдлыг нэмэгдүүлэх

Намын төлөөллийн төв байгууллагад шинээр болон нөхөн сонгогдсон гишүүдийг батламжлах асуудлыг Намын Их Хурлаар тухай бүр хэлэлцүүлэхгүйгээр төлөөллийн төв байгууллагын нийт гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэх эрх зүйн нөхцөлийг бүрдүүлнэ. Ингэснээр намын дотоод үйл ажиллагааны тасралтгүй байдал хангагдаж, шийдвэр гаргах ажиллагааны шуурхай байдал, үр нөлөө нэмэгдэхийн зэрэгцээ зохион байгуулалтын болон санхүүгийн зардал буурна. Түүнчлэн эвлэлдэн нэгдэх эрхийг хэрэгжүүлэх институтийн үр нөлөөг дээшлүүлж, Үндсэн хуульд заасан ардчилсан ёс, өөрөө удирдах зарчимтай нийцсэн зохицуулалт бүрдэнэ.

3.3.Намын санхүүжилтийн зохицуулалтыг бодит байдалтай нийцүүлэх

Иргэн, хуулийн этгээдээс улс төрийн намд өгөх хандивын хэмжээг эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, инфляцын түвшин болон сонгуулийн үйл ажиллагааны бодит зардлын хэрэгцээтэй уялдуулан шинэчлэн тогтооно. Мөн “Компанийн тухай хууль”-д заасан бие даасан хуулийн этгээдийн зарчимтай нийцүүлнэ.

Энэхүү зохицуулалтын үр дүнд хууль ёсны санхүүжилтийн эх үүсвэрийг дэмжих, санхүүгийн ил тод байдал, тайлагнал, аудит, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, далд болон хууль бус санхүүжилтийн эрсдэлийг бууруулах нөхцөл бүрдэнэ. Түүнчлэн иргэн, хуулийн этгээдийн улс төрийн оролцоог эрх тэгш хангах, компанийн эрх зүйн бие даасан байдлыг хамгаалах, ойлгомжтой бөгөөд хэрэгжих боломжтой эрх зүйн зохицуулалтыг бий болгох ач холбогдолтой.

Дөрөв.Хуулийн төсөл батлагдсанаар гарах үр дүн

Хуулийн төсөл батлагдсанаар дараах үр дүн гарна: Үүнд:

- Орон нутгийн намын байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны бие даасан байдал хангагдаж, өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн нөхцөл сайжирна;

- Улс төрийн намын дотоод зохион байгуулалт боловсронгуй болж, шийдвэр гаргах үйл ажиллагааны шуурхай байдал нэмэгдэнэ;
- Улс төрийн намын санхүүгийн ил тод байдал, тайлагнал, хяналт, аудитын үр нөлөө дээшилж, далд болон хууль бус санхүүжилтийн эрсдэлийг бууруулна;
- Иргэн, хуулийн этгээдийн улс төрийн оролцооны эрхийн хэрэгжилт сайжрахгаас гадна Үндсэн хуулийн эрх тэгш байдал, эвлэлдэн нэгдэх эрх, шударга ёсны зарчим илүү хангагдана.

Тав.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай нийцэх байдал

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн:

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ардчилал, шударга ёс, тэгш байдлын зарчим;
- Арван дөрөвдүгээр зүйлд заасан эрх тэгш байдлын зарчим;
- Арван зургаадугаар зүйлийн 10 дахь хэсэгт заасан эвлэлдэн нэгдэх эрх;
- Арван есдүгээр зүйлд заасан хүний эрх, эрх чөлөөг хангах төрийн үүрэг зэрэг суурь зарчимтай нийцнэ. Мөн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон Компанийн тухай хуулийн үзэл баримтлалтай харшлахгүй болно.

Иймд хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцсэн гэж үзэж байна.